

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар

“Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл” гэсэн 40 дүгээр зүйлийн “Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:” гэсэн 40.1 дэх заалтад “40.1.2. өөр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байх. Тайлбар: -Энэ заалтыг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө.” гэж заажээ. Энэ заалтаас үзвэл сумын болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчөөр давхар ажиллаж болохгүйгээр хуульчлагджээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-ийн “Төлөөлөгчид нэр дэвшүүлэх эрх” гэсэн 6 дугаар зүйлд “6.5.Сум, дүүргийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшигч нь аймаг, нийслэлийн Хурлын Төлөөлөгчид зэрэг нэр дэвшиж болно.” гэж, мөн **“Нэр дэвшүүлэх нийтлэг журам”** гэсэн 28 дугаар зүйлд “28.6.Энэ хуулийн 6.5-д зааснаас бусад тохиолдолд нэр дэвшигч нэгээс илүү тойрогт нэр дэвшихийг хориглоно” гэж заажээ. Эдгээр заалтаас үзэхэд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшигч нь аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Төлөөлөгчид давхар нэр дэвшиж болохоор ойлгогдож байна.

Дурдаж буй хуулиудын заалтууд нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болно.

“Иргэний хууль”-ийн “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ.” гэсэн 3.3 дахь заалтын дагуу энэ асуудлыг шийдвэрлэхэд боломжгүй мэт ойлгогдож байна. Учир нь энэ хоёр хууль нь нэг асуудлыг биш тус тусын буюу нэг нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үйл ажиллагааг нөгөө нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааг зохицуулж байгаа.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-ийг баримтлан Сумын болон Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчөөр давхар нэр дэвшиж сонгогдсон нөхцөлд Төлөөлөгчийн бүрэн эрхээ хүлээн зөвшөөрүүлж Хурлын үйл ажиллагаанд оролцох боломжгүй болж маргаан гарч болзошгүй байна.

Мөн “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн “40.1.2. өөр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байх. Тайлбар: -Энэ заалтыг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө.” гэж заасныг дагаж мөрдөснөөр давхар

сонгогдсон ИТХ-ын төлөөлөгч нь аль нэг хурлын төлөөлөгчөөр ажиллахаас татгалзах шаардлагатай болж байгаа тул олон тооны нөхөн болон дахин сонгууль зарлан явуулах бодит эрсдэл үүсэж байна.

Иймд хуулийн зөрчлийг арилгаж хуулиудын нийцлийг хангах зайлшгүй шаардлагад үндэслэн хуулийн төслийг боловсруулсан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар

“Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл” гэсэн 40 дүгээр зүйлийн “Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:” гэсэн 40.1 дэх заалтад “40.1.2. өөр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байх. Тайлбар: -Энэ заалтыг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө.” гэж заажээ. Энэ заалтаас үзвэл сумын болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчөөр давхар ажиллаж болохгүйгээр хуульчлагджээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-ийн “Төлөөлөгчид нэр дэвшүүлэх эрх” гэсэн 6 дугаар зүйлд “6.5.Сум, дүүргийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшигч нь аймаг, нийслэлийн Хурлын Төлөөлөгчид зэрэг нэр дэвшиж болно.” гэж, мөн “Нэр дэвшүүлэх нийтлэг журам” гэсэн 28 дугаар зүйлд “28.6.Энэ хуулийн 6.5-д зааснаас бусад тохиолдолд нэр дэвшигч нэгээс илүү тойрогт нэр дэвшихийг хориглоно” гэж заажээ. Эдгээр заалтаас үзэхэд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшигч нь аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Төлөөлөгчид давхар нэр дэвшиж болохоор ойлгогдож байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-ийн дагуу давхар нэр дэвшиж, шат шатны сонгуульд давхар сонгогдсон ИТХ-ын төлөөлөгч нь “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн заалтаар давхар ажиллах боломжгүй болж байгаа тул эдгээр хуулийн зөрчлийг арилгаж хуулиудын нийцлийг хангах зайлшгүй шаардлага гарсан тул хуулийн төслийг боловсруулсан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ